

САЙД ЯРЬЖ БАЙН



Тэрх зургийг Г.АРТУУЖИН

УЛС ТӨР

ХҮҮХДИЙН ТЭВЧИШГҮЙ
ХӨДӨЛМӨРИЙГ ХАМТДАА УСТГАХЫГ
УРИАЛАВ

II нүүрт

ДЭЛХИЙ

БОЛИВИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ НУУЦ
ХҮҮТЭЙ ЮУ

VI нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ДЭЛХИЙН БРЭНД БИШ ДЭРГЭД БАЙГАА МОНГОЛ БРЭНДЭЭР “БАЯРХДАГ” ЦАГ ИРЖЭЭ

Б.ӨНӨРТӨГТОХ

Монгол Улсын эдийн засаг 17 хувьд хүрч, Монголын тэргүүн баячууд жорлонгийн суултуураа хүртэл гаднаас зөөж “гангардаг” цаг үе дөрвөн жилийн өмнө бидэнд байлаа. Бүр мантуу, сүүтээ өмнөд хөршөөс зөөж, польш огурцы таваглаж тансаглаж байсан цаг саяхан. Англи, Америкийн алдартай брэндүүд ар араасаа Монголд салбар дэлгүүрээ нээгээд л өнгөц харахад бид дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаад

ч байгаа юм шиг. Баян тансаг амьдралд бялуурч, бүгд машин унах хүртлээ хөлжсөн ч юм шиг. Гэвч энэ сайхан мөрөөдөл, үлгэрийн амьдрал харамсалтай нь багахан мөнгөөр тансагласан түр зуурын зугаа цэнгэл төдий байлаа. Хадгаламж нээж хуримтлал үүсгээгүй, эс бөгөөс хэрэгтэй зүйлд хөрөнгө оруулалт хийлгүй олсон хэдэн төгрөгөө баруун солгойгүй цацдаг шинэ баян шиг л сэтгэж байжээ, бид.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

С.ЭРДЭНЭ: 1072 ХУВЬЦААНЫ 30 ХУВИЙГ ХУДАЛДАЖ АВАХ АСУУДАЛ СОНГУУЛЬТАЙ ЯМАР Ч ХАМААГҮЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

СОНГУУЛЬ-2016

НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМ Э.БАТ-ҮҮЛИЙГ ХОТЫН ДАРГААР ДАХИН СОНГОХОО МЭДЭГДЭВ

Э.ТУУЛ

УИХ-ын гишүүн болон аймаг, нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчдийг сонгох сонгууль энэ сарын 29-ний өдөр болно. Тэгвэл өнгөрсөн бямба гарагт буюу энэ сарын 11-ний өдөр УИХ-ын гишүүн болон аймаг, нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчдийг сонгох сонгуулийн сурталчилгааны албан ёсны нээлт боллоо. Нийслэлийн Ардчилсан нам



Тэрх зургийг Г.АРТУУЖИН

Монгол бөхийн өргөөнөө сонгуулийн сурталчилгааны нээлтийн ажиллагаагаа зохион байгуулав. Нийслэлийн Ардчилсан намаас НИТХ-ын

сонгуульд есөн дүүргийн 45 тойрогт 45 хүн нэр дэвшиж байгаа юм.

Үргэлжлэл нь II нүүрт

МЭРГЭЖИЛТНИЙ ҮГ

Э.ИХБАЯР: МОНГОЛ УЛСЫН ХУВЬД ЖИНЖОУ БООМТ ХАМГИЙН ОЙРХОН ДАЛАЙД ГАРАХ ГАРЦ

Б.ТОГТОХ

Зам тээврийн яамны харьяа Далайн захиргааны тээвэр, ложистик харууцсан мэргэжилтэн Э.Ихбаяртай далайн цаг үеийн асуудлаар ярилцлаа. Тэрбээр, БНХАУ-ын Жинжоу боомт хотод Зам тээврийн яамны харьяа Далайн захиргааны газраас төлөөлөгчөөр томилогджээ.

-БНХАУ-ын Жинжоу боомтод Зам тээврийн яам Далайн захиргаа өөрийн төлөөлөгчийн газраа нээсэн байна. Энэ талаар мэдээлэл өгөөч. Таны хувьд төлөөлөгчөөр томилогдсон байна шүү дээ?

-Монгол Улсын экспорт, импортын бараа эргэлтийн дийлэнх хувийг хувийг БНХАУ-ын Тяньжин боомтоор дамжуулан хоёр

улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэж байгаа. Гэсэн ч та бүхэн санаж буй бол өнгөрсөн жил Тяньжин боомтод гарсан томоохон хэмжээний гамшгаас үүдэж өмнөд хөрш маань нийслэлээрээ дамжуулж химийн гаралтай аюултай бараа бүтээгдэхүүн болон нефть зэрэг шатамхай шингэн таворыг тээвэрлэхээс татгалзаж эхэлсэн. Тэр утгаараа, Жинжоу боомтоор бид эхний ээлжинд нефтийн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн зориулалттай шатамхай бодисыг тээвэрлэх юм. Хоёр талдаа гарц нээгдлээ гэж хэлж болно. Манайхаас БНХАУ руу цаашлаад тус далайн боомтоор дамжаад олон улсад гарах зорилт тавьж байгаа. БНХАУ-ын хувьд ч өртөг багатайгаар тээвэрлэх гарцыг талархан дэмжсэн.

Үргэлжлэл нь IV нүүрт

Хонг Конг нислэг
5th Anniversary

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд 44 дугаар захиалгын үнэ 15400

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

| ХААН Банк | | | Худалгаа хөгжлийн банк | | |
|-----------|---------|---------|------------------------|---------|---------|
| | Авах | Зарах | | Авах | Зарах |
| АМ.ДОЛЛАР | 1968.00 | 1984.00 | ФУНТ | 2800.00 | 2886.00 |
| ЕВРО | 2205.00 | 2260.00 | РУБЛЬ | 28.60 | 32.60 |
| ИЕН | 18.22 | 18.70 | ЮАНЬ | 299.00 | 302.00 |
| | | | АМ.ДОЛЛАР | 1970.00 | 1983.00 |
| | | | ЕВРО | 2185.00 | 2276.00 |
| | | | РУБЛЬ | 28.60 | 33.06 |
| | | | ЮАНЬ | 298.80 | 302.40 |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

СОНГУУЛЬ-2016

НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМ Э.БАТ-ҮҮЛИЙГ ХОТЫН ДАРГААР

Үргэлжлэл.
Түүрүүч нь I нүүрт

Өнгөрсөн дөрвөн жил НИТХ-ын даргаар ажилласан Д.Баттулга нийт нэр дэвшигчдийг танилцуулсны дараа НИТХ-ын 2016 оны сонгуулийн сурталчилгаагаар албан ёсоор эхлүүлсэн мэдэгдэв. Түүнчлэн нийслэлийн ИТХ-д нэр дэвшигчид энэ өдөр анхдугаар хуралдаанаа хийлээ. Тус хуралдаанаар хоёр асуудал хэлэлцсэн эхнийх нь эхлүүлсэн ажлаа эрчимжүүлэх, улам илүү нэмэгдүүлэх “5+” мөрийн хөтөлбөрийг танилцуулах байв. “5А” мөрийн хөтөлбөрийн үргэлжлэл болох “5+” мөрийн хөтөлбөрийг өнгөрсөн дөрвөн жилд Нийслэлийн Засаг дарга буюу Улаанбаатар хотын захирагчаар ажилласан Э.Бат-Үүл танилцууллаа.

Э.Бат-Үүл: Зангидсан гар мэт ажиллахаар надтай хамт нэр дэвшиж буй 44 төлөөлөгчийг дэмжиж өгөөрэй

/Нийслэлийн Засаг дарга буюу Улаанбаатар хотын Захирагч/

Юуны өмнө 2012-2016 онд нийслэлд Ардчилсан нам анх удаа олонхи болж, бидэнд итгэл үзүүлж, сонгосон нийслэлчүүдээ талархлаа илэрхийлэхийг хүсч байна. Бид тэднийхээ итгэл найдвар, нэр төрийг өндөрт өргөж яваа. Өнгөрсөн дөрвөн жил хийсэн ажилд маань нийслэлчүүд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж байна. Тиймээс ирэх дөрвөн жилд нийслэл хотоо улам хөгжүүлэх их ажлынхаа хөтөлбөрийг танилцуулах гэж байна. Манай нийслэлчүүдийн хамгийн их талархан хүлээж авсан ажил бол төрийн



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

үйлчилгээг нийслэлчүүдэд түргэн шуурхай үзүүлэх Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулсан явдал юм. Энэ төвийн үйлчилгээг одоогоор Баянзүрх дүүргийн “Дунжингарав”, Хан-Уул дүүргийн “Мишээл экспо”, Сонгинохайрхан дүүргийн “Драгон” төвд тус тус байгуулсан. Тэгвэл тун удахгүй Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэддээ төрийн үйлчилгээг ойртуулахаар “Бөмбөгөр” худалдааны төвд нээхээр ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар энэ төвүүдээр 250 мянган хүн хүнд сурталгүй, авлига хээл хахуульгүй төрийн үйлчилгээг аваад байна. Хэзээ ч төрийн үйлчилгээг ийм олон хүн цаг хугацаа хэмнэж, чирэгдэлгүй авч байгаагүй. Тиймээс цаашид төрийн үйлчилгээг түгжрэлгүй хүргэдэг үйлчилгээний нэгдсэн төвийн дүүрэг бүрт байгуулах зорилго тавиад байна. Мөн нийслэлд өнгөрсөн дөрвөн жил 244 км замыг шинээр тавьсан бол ирэх дөрвөн жил 205.7 км замыг шинээр тавихаар төлөвлөсөн. Дээрээс нь манай иргэдийн хүсэн хүлээдэг нэг зам нь дугуйн зам болсон. Бид ирэх дөрвөн жил 22.4 км дугуйн зам тавина. Одоо байгаа дугуйн замын хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлнэ гэдгээ зарлаж байна. 2016-2020 оны хооронд 43.7 км цэвэр усны пугамыг шинэчилнэ. Энэ нь гэр хорооллын хашааны газар дээр баригдах шинэ орон сууцны том хотхон хорооллуудыг цэвэр усаар хангах ажил болно. Цахилгаан станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлснээр шинээр байгуулах хороолол хотхонуудаа дулаан, цахилгаанаар хангах

бүрэн боломжтой болсон. Цахим карттай, ухаалаг нийтийн тээвэрт бид шилжсэн. Энэ ажлыг манай нийслэлчүүд маш их дэмжсэн. Нийтийн тээврийн шинэчлэлээ улам нэмэгдүүлж, 650 автобусаар парк шинэчлэл хийнэ. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг бид цаашид үргэлжлүүлнэ. 24 байршилд энэ ажлыг явагдаж байна. Дээрээс нь манай нийслэлчүүд нэгдээд хашааны газар дээрээ орон сууцны хороолол барих ажлаа эхлүүлээд байна. Бид ирэх дөрвөн жил доод тал нь 71000 айл өрхийг орон сууцжуулна гэдгийг эндээс мэдэгдэхэд таатай байна. Өнгөрсөн дөрвөн жилд бид 96 цэцэрлэг, сургуулийг ашиглалтад оруулсан. Зарим нөхдүүд бидний хийсэн ажлыг харлуулж, өөлөхдөө “Ногоон уут тарааж байхаар цэцэрлэг, сургууль барихгүй яасан юм” гэж биднээс ам асууж байсан. Хуулиараа бол хог хаягдлын мөнгө хог хаягдалдаа, сургууль, цэцэрлэгийн мөнгө сургууль, цэцэрлэгтээ л зарцуулагдах ёстой. Тэгж асууж байсан хүмүүсээс бид 3-4 дахин их сургууль, цэцэрлэгийг ашиглалтад оруулахын зэрэгцээ хогоо ч цэвэрлэж чадсан гэдгийг хэлэхийг хүсч байна. Бид сургууль, цэцэрлэгийн суудал орны хэмжээг 25 мянгаар нэмэгдүүлсэн. Ирэх дөрвөн жилд шинэ цэцэрлэг 50, шинэ сургууль 30-ыг, сургууль цэцэрлэгийн 88 цогцолборыг ашиглалтад оруулна. Мөн эрүүл мэндийн асуудалд анхаарах хандуулж, хоёр амаржих газар, гурван дүүрэгт нэгдсэн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна. Дараа нь гэр хорооллын гудамжуудаа гэрэлтүүлгээтэй, хяналтын камертай болгох тал

дээр улам их анхаарна. Өнгөрсөн дөрвөн жил гэр хороололд 21 мянган гэрэлтүүлэг тавьсан бол ирэх дөрвөн жилд ч мөн үргэлжлүүлнэ. Пахи газар олголт, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн гээд нийслэлээ улам их хөгжүүлнэ, цэцэрлүүлнэ гэдгээ та бүхэнд энэ индрээс хэлэхэд таатай байна. Амаргүй энэ их ажлыг хийж, гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн 26 төлөөлөгчдөө, бшөөндөр энэ хурлыг удирдаж буй миний найдвартай түшиг тулгуур болсон Д.Баттулгадаа талархал илэрхийлнэ. Одоо зангидсан гар мэт ажиллаж, Улаанбаатар хотыг дэлхийн атаархам сайхан хот болгохын төлөө надтай хамт нэр дэвшиж буй 44 төлөөлөгчийг дэмжиж өгөөрэй хэмээн нийслэлчүүддээ уриалмаар байна.

НИТХ-ын анхны хуралдаан хэлэлцэх асуудлынхаа хоёр дахь буюу “5+” төлөвлөгөөг хэрэгжүүлэх багийн ахлагчийг сонгох асуудлыг хэлэлцсэнээр үргэлжиллээ. Тэд өнгөрсөн дөрвөн жилд Улаанбаатар хотод их бүтээн байгуулалтын ажил өрнүүлсэн Эрдэнийн Бат-Үүлийг санал нэгтгэжээ. Хотын даргад нэрлэж, олон нийтэд зарласан юм. Нийслэл Улаанбаатар хотын хөгжил ухрах ёсгүйг санаж, урагшилж эхэлсэн өнөөдрөө дүнээж улам урагшлах ирэх жилүүдийг бодсон сонгууль болно гэдгээ Э.Бат-Үүлийн баг итгэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Хотын дарга хэрхэн сонгодог вэ

Нийслэлийн Засаг дарга

бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг нийслэлийн ИТХ-д хуралд олонхи болсон нам томилдог. Э.Бат-Үүлийг хотын даргаар дахиульга гэвэл, сүүлийн дөрвөн жилд хийсэн ажлыг нь үргэлжлүүлнэ гэж хүсвэл багаар нь дэмжих ёстой. Өөрөөр хэлбэл, Бат-Үүлийг багаар нь дахиульга гэвэл нийслэлийн ИТХ-д нийслэлийн Ардчилсан намын нэр дэвшигчдийг сонгоно. Нийслэлийн ИТХ-ын сонгууль нь алхдаг гудамж, явдаг зам, зорчдог автобус, сургууль, цэцэрлэг, ус дулаан, амьдрах орчноо ямар байхыг шийддэг бодитой сонголт юм. Тиймээс нийслэлийн иргэн таны оролцоо их бийг энэ дашрамд сануульга.

Улаанбаатар ухрах уу, урагшлах уу

Э.Бат-Үүлийн баг өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Улаанбаатар хотыг харанхуй гудамж, хавчиг замаас салгаж, бүтээн байгуулалтын “бослого” өрнүүлсэн билээ. 2012 Оноос өмнөх үеэс сүүлийн жилүүдэд шинээр тавьсан, шинэчилж өргөтгөсөн зам гэхэд л гурав дахин их байна. Нийслэлийн үйлчилгээний анхны нэгдсэн төв Баянзүрх дүүргийн “Дунжингарав”-т энэ оны ажлын эхний өдөр үүдээ нээв. Гурван сарын дараа Хан-Уулын “Мишээл экспо”, Сонгинохайрханы “Драгон” гэдэг хоёр “дүү” дагуулав. Дахиад ч зургаан “дүү” дагуулах нь тодорхой болсон. Гэр хорооллын дахин төлөвлөлт 2013 онд эхэлж, хотын хүн амын ес, газар нутгийн 14 хувийг хамран 7374 айлын орон сууц барьж байна. Харин 4044 өрх буюу 16 мянга гаруй иргэн хашааны газраа шинэ байраар сольж хот дотроо их нүүдэл хийжээ. Энэ мэтээр нийслэл хот маань сүүлийн жилүүдэд өнгө төрхөө танигдахын аргагүй өөрчлөгдсөн. Үүнтэй санал нийлэхгүй хүн нийслэлд үгүй биз ээ. Тиймээс ч Э.Бат-Үүлийн баг зам, сургууль, цэцэрлэг барих, хот тохижилт, нийтийн тээвэр, төрийн үйлчилгээний супермаркетууд, гэр хорооллын дахин төлөвлөлт, цахим газар олголт зэрэг дорвитой хийсэн ажилтай, шийдсэн асуудал олонтой ээлжит сонгуульдаа орлоо. Дашрам сонирхуулахад, Э.Бат-Үүлийн багийн гишүүд болох 45 нэр дэвшигч нь дунджаар ид хийж бүтээх 45 настай, инженер, эдийн засагч, менежер, хуульч мэргэжилтэй бүтээлч хүмүүс байна. Одоо нийслэлчүүд бидний сонголт л үлддэг. Улаанбаатар ухрах уу, урагшлах уу гэдгийг та, би, бид шийднэ.

АН ард түмэнтэйгээ сонгуулийн сурталчилгаагаар эхлүүлээ

Орон даяар нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа өнгөрөгч бямба гарагаас эхэллээ. Тодруулбал, 2016 оны УИХ-ын 76 суудлын төлөө 12 нам, гурван эвслийн 429 нэр дэвшигч, 69 бие даагч, нийт 498 хүн өрсөлдөхөөр сонгуулийнхаа сурталчилгааг эхлүүлж байна. Нэр дэвшигчдийн 215 нь аймаг орон нутагт, 283 нь нийслэлийн тойрогт өрсөлдөх юм. Дээрх нэр дэвшигчдийн 129 нь эмэгтэй хэмээн СЕХ-ноос мэдэгдсэн билээ.

Улс төрийн намуудаас АН, МАН тойрог бүрт нэг буюу 76 хүн, МАХН 71, Тусгаар тогтнол, эв нэгдлийн эвсэл 44, Бүгд найрамдах нам 36, Иргэний хөдөлгөөний нам 27, Социал Демократ нам 17, ИЗНН 15, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч болоод Хаан сонголт эвсэл тус бүр есөн нэр дэвшигчийг тус бүр дөвшүүлж буй юм. Ардчилсан намын нэр дэвшигчид энэ удаад ард түмэнтэйгээ сонгуулийн сурталчилгааны нээлтээ хийлээ. Тэд нэгдсэн зохион байгуулалтад орж, нүсэр шоу арга хэмжээ хийхийг зорьсонгүй. Харин 76 нэр дэвшигч тойрог бүртээ иргэдтэйгээ уулзаж сурталчилгааны нээлтээ хийсэн юм. Тухайлбал, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Дундговь аймгийн нэр дэвшигчдээс гадна нийслэлийн дүүргүүдэд нэр дэвшигчид малчны хотоос хуртгал сурталчилгаагаар эхлүүлнэ. Харин МАХН-ын Сонгуулийн сурталчилгааны нээлтний арга хэмжээ Crocus Event Hall-д боллоо.

М.Энхболд: Бид сэрэх, шинээр сэтгэх цаг нь болсон

Монголын улс төрийн ууган гучин МАН өнгөрөгч бямба гаратг Тусгаар тогтнолын их танхимд морин цагт сонгуулийн сурталчилгааны нээлтээ хийлээ. Голдуу залуучууддаа итгэл хүлээлгэсэн ууган намын сонгуулийн нээлт ёслол төгөлдөр болсон юм. Энэ удаагийн сонгуульд Монгол Ардын Нам “Бид зүтгэнэ - Хамтдаа хөгжинэ” гэсэн уриатай орж байгаа аж. Монгол Ардын Намын сонгуулийн нээлтэд МАН-ын дарга М.Энхболд үг хэлэв. Тэрбээр, “Ардчиллын амьд биелэл болсон төрөө засан тохинуулах эрхээ, ард олон бид 1460 хоногт ганц удаа эдэлдэг, тэр эрхэм үйлсийнхээ босгон дээр тулж ирээд байна. Энэ эрхийг зөв эдэлбэл улс орны болоод айл өрхийн хувь заяаг тэгшитгэж, хөгжил дэвшлийн үүд хаалгыг нээж өгнө. Буруу эдэлбэл хор уршиг нь дөрвөн жилээр барахгүй, 40 жил, дөрвөн үеэрээ ч засч зарлуулахын аргагүй эрсдэл дагуулж болзошгүй.

Иймд улс орны эдийн засаг, нийгмийн болон улс төрийн нөхцөл байдал ямар байгааг төрийн сонгуульд оролцож байгаа улс төрийн нам, нэр дэвшигчид, сонгогч хэн ч байсан чин сэтгэлээсээ, үнэн бодитой үнэлж дүгнэн, дор бүрнээ нэгийг бодоцгооё. Эрх баригчдын алдаатай бодлого эдийн засгийг элгээр нь хэвтүүлж, улс орноо өргийн дарамтанд орууллаа. Түмэн олноо ядууруулж, төрдөө итгэх итгэлийг нь алдагдууллаа. Эрүүл энх аж төрж, эрдэм боловсрол эзэмших боломж хумигдаж байна. Засаглалын чадвархи илт суларч, хуулийн уламдаа гишгэж, дур зоргоор авирлах явдал хэрээс хэтэрлээ. Бид сэрэх, шинээр сэтгэх, зүтгэх болсон гэдгийг Монгол Ардын Нам ашид нотод ойлгож байна. Манай намд улс орноо сүйрлээс сэргийлж, уналтаас босгож, эдийн засгаа сэргээж явсан туршилага, мэдлэг, чадварт суурилан хичээн зүтгэхээ илэрхийлээ.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**
Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг хамтдаа устгахыг уриалав

Б.САРНАЙ

ХАХНХЯ, Хөдөлмөрийн яам, Хүүхдийн төлөө үндэсний газар болон хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын төлөөлөл хамтран өнгөрөгч баасан гаратг “Бараа нийлүүлэлтийн сүлжээн дэх хүүхдийн хөдөлмөрийг хориглоё” сэдэвт хурлыг “Монгол ноёс” мэдээллийн төвд зохион байгууллаа. Хэвлэлийн хуралд Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, ХАХНХЯ-ны Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Х.Баавгай болон албаны бусад хүмүүс оролцсон юм. Энэ үеэр ХАХНХЯ-ны Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Х.Баавгай “Ажил үйлчилгээ гэдэг нь бүх

талын нийлүүлэлттэй. Ямар ч нийлүүлэлт байж болно. Тухайлбал, архи, согтууруулах ундааны нийлүүлэлт магадгүй хууль бус бараа гүйлгээний нийлүүлэлт, хар тамхи, ман-сууруулах бодис ч юм уу бүр цаашилбал, янз янзын ажил үйлчилгээнүүд байна. Эсвэл массажны үйлчилгээ гэх мэт садар самуун, хүчирхийллийг сурталчилсан үйл ажиллагаанд хүүхдийг уруу татах зэрэг бүхий л бараа, ажил үйлчилгээг нийтэд нь нийлүүлэлт гэж нэрлэж байгаа юм. Нийлүүлэлтийн сүлжээнд ажил эрхэлж буй 168 сая орчим насанд хүрээгүй хүүхэд дэлхий дээр байдаг. Харин манайд хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо 100 мянга байна. Үүнээс 10 мянга нь

тэвчишгүй буюу хүнд хэцүү ажил эрхэлж байна гэсэн судалгааны дүн гарсан. Хүнд хэцүү ажилд нь барилга, уул уурхайн нөхцөл, саун массажны үйлчилгээ зэрэг багтана” хэмээн онцлоо. Харин Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан “Хөдөлмөрийн сайдын тушаалаар “Насанд массажны үйлчилгээний хураангуй хуулиар ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг шинэчлэн баталсан. Уг жагсаалтад хүүхдийн хөдөлмөрийн ялангуяа тэвчишгүй хөдөлмөрийг илүү онцлон анхаарсан. Тухайлбал, өвлийн улиралд хурдан морины уралдаан зохион байгуулж, түүнд хүүхдээр морь унуулахыг хориглох заалтыг шинээр оруулсан. Мөн барилгын салбарт хүүхэд ажиллуулах, авто зам,

гудамжаар бараа бүтээгдэхүүн заруулах, химийн хортой болон уул уурхайн нөхцөлд хүүхэд ажиллуулахыг хориглосон заалтууд орсон юм. Энэ журмыг багтана” хэмээн онцлоо. Хөдөлмөрийн яам өөрийн зүгээс хүүхдүүдийн эрх ашгийн төлөө ажлаа хийж байгаа гэдгийг энэ дашрамд дуулга” гэлээ. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг зогсоох нь гэр бүлээс нь эхлээд ажил олгогчид, хүүхдийн төлөө ажилладаг байгууллагын ажилтнууд болон нийт хүмүүс анхаарах ёстой асуудал гэдгийг хуралд оролцогчид онцолж байсан юм. Мөн хүүхдийн төлөө “тэвчишгүй хөдөлмөр”-ийг хамтдаа устгаа хэмээн уриалсныг дуулга.

Д.Оюунхоролыг нэр дэвшсэнд баянзүрхчүүд баяртай байна

УИХ-ын сонгуулийн 49 дүгээр тойрогт МАН-аас нэр дэвшигч Д.Оюунхоролын сонгогчидтойгоо хийсэн дараагийн уулзалт асуулт хариулт, санал сэтгэгдэл илтэй үргэлжиллээ. Баянзүрх дүүргийн МАН-ын гишүүн, идэвхтэн сонгуультан, дэмжигчид нийлсэн 1000 орчим хүн танхим дүүрэн цугларч, намынхаа нэр дэвшигчийг халуун алга ташилтаар угтан авсан нь энэ дүүргийн иргэд, сонгогчдыг төлөөлөх Д.Оюунхорол шиг хүн үнэхээр хэрэгтэй байсан нь илэрхий. Нэр дэвшигч Д.Оюунхорол “Баянзүрх

дүүргийн МАН-ын гишүүд, дэмжигчид бол тус намын суурь үндсийг бүрдүүлдэг чухал баг хамт олон болохыг онцлоод, нэр дэвшигчийн сонгуулийн штабын үйл ажиллагаа жигдэрч, шударга өрсөлдөхөд бэлэн болсон” хэмээн зарлалаа. Тус дүүргийн МАН-ын гишүүд, идэвхтэн, сонгогчид оршин суугчдын шилжилт хөдөлгөөн, ажилгүйдэл, ядуурал, өвчлөл ихтэй, иргэдийн амьдралд тулгамдсан, шийдвэрлэвэл зохилтой олон асуудал төрийн бодлогоос гадуур орхигдож байдаг энэ дүүрэгт нүдээ олсон хүнийг нам илгээсэнд сэтгэл

хангалуун байгаа аж. Нийслэл хотын хүн амын 23 хувь нь амьдардаг Баянзүрх дүүрэгт ерөнхий боловсролын сургуульгүй хороо ч байгаа нь тус дүүрэгт нийгмийн асуудлууд ямар их хуримтлагдсаныг харуулна. Нэр дэвшигч Д.Оюунхорол Баянзүрх дүүргийн иргэд сонгогчдын итгэлийг хүлээн сонгогчдоод эдгээр олон бэрхшээлтэй асуудлыг анхаарч ажиллан, МАН-ын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу шийдвэрлүүлэхийн төлөө өөрийн туршлага, мэдлэг, чадварт суурилан хичээн зүтгэхээ илэрхийлээ.

УЛС ТӨР

МЭРГЭЖИЛТНИЙ ҮГ

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

БНХАУ-ын дарга Си Зиньпин 2014 оны наймдугаар сард Монгол Улсад төрийн айлчлал хийхдээ өөрийн улсын Хебей, Ляонинг мужийн гадаад худалдаанд нээлттэй боомтуудыг Монгол Улсад нээлттэй ашиглах "Монгол Улс, Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай" хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсан байдаг. Энэ хэлэлцээр М.Зоригт сайдын үед илүү эрчимтэй яригдаж, ажил хэрэг болж чадлаа. М.Зоригт сайд урд хөршийн далайн боомтоор тээвэрлэгдэж байгаа бараа, ачаа эргэлтийн урсгал нэмэгдүүлэх, улмаар ачааллыг бууруулах талаар анхаарч ажиллаж Жинжоу боомтын удирдлагуудтай харилцан тохиролцож чадсан юм билээ. Энэ тохиролцооны үндсэн дээр тус боомтод төлөөлөгчийн газраа нээсэн. Миний хувьд тус боомт хотод төлөөлөгчөөр ажиллах юм. Боомтод төлөөлөгчийн газраа



Гэрэл зургийг Г.АРИУНЗАЯА

Э.ИХБАЯР:

МОНГОЛ УЛСЫН ХУВЬД ЖИНЖОУ БООМТ ХАМГИЙН ОЙРХОН ДАЛАЙД ГАРАХ ГАРЦ

нээх албан ёсны хэлэлцээр өнгөрөгч тавдугаар сарын 16-нд зурагдаж, тухайн сарынхаа 24-нд албан ёсоор төлөөлөгчийн газраа бүртгүүлж бичиг баримтаа авлаа.

М.Зоригт сайдын үед ажил хэрэг болж чадлаа гэж та хэлж байна. Боомтод төлөөлөгчийн газраа нээх сонирхол яг хэзээнээс яригдаж эхэлсэн юм бол?

-2011 оноос гэж хэлж болох юм. 2011 оны аравдугаар сард "Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа"-ны дөрөв дэх хурал Жинжоу хотноо болсон байдаг. Тэр үед УИХ-ын гишүүн Ч.Улаан, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Батсуурь тэргүүтэй Монголын төлөөлөгчид Жинжоу боомтын чингэлгийн ачааны зогсоолтой танилцсан. Түүнчлэн, 2013 оны тавдугаар сарын 20-нд Жинжоу хотын төлөөлөгчид Улаанбаатар хотноо болсон Европ Азийг холбосон шинэ төмөр замын шугам барих төслийн тавдугаар хуралд оролцсон. Мөн онхуо аравдугаар сард Ерөнхий сайд Н.Алтанхуяг БНХАУ-ын Орон сууц хот төлөөлөлтийн яамны сайд Ченжен Гаотай уулзахдаа Чойбалсан-Ляонин

төмөр замаар дамжин далайд гарах шинэ гарцын талаар ярьсан байдаг. Гэх мэтээр хоёр улсын хооронд яриа хэлэлцээр явж байсан. Гэхдээ БНХАУ-ын дарга Си Зиньпиний төрийн айлчлалын үед энэ асуудал Засгийн газрын төвшинд яригдаж, М.Зоригт сайдын үед ажил хэрэг болсон гэж хэлж болно. Таван жилийн хугацаанд л хоёр талын ашиг сонирхол шинэ гарц нээхэд чиглэж ирсэн байгаа юм.

Тяньжин боомтоор бараа тээвэрлэхээс илүү цаг хугацаа, мөн зардал хэмнэх нь гэж ойлгож болох уу?

-Болно л доо. Жинжоу боомт Монгол Улсын хувьд хамгийн ойрхон далайн гарц гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл, Жинжоу боомт БНХАУ-ын Бохай тэнгисийн эргийн шугам дагуух 400 км доторх нэгдсэн чөлөөт бүс бүхий цорын ганц олон улсын худалдааны боомт. Монгол Улс, БНХАУ-ын Өвөрмонголын Шилийн гол аймагтаа хамгийн ойр оршиж буй далайн гарц. Өвөрмонголын Шилийн гол аймгийн Зүүн хатавч боомтоос Бажу-Баши-Чида төмөр зам-Жинчи-Жинжоу боомт гэсэн маршрутаар ачаа тээвэрлэхэд

...Зам тээврийн яам, цаашлаад Засгийн газрын төвшинд яригдаж, шийдэгдэх бодлогын асуудал. Миний хувьд зөвхөн хоёр улсын тээвэрлэлтийн асуудалд төлөөлөгчөөр ажиллах үүрэгтэй хүн. Чойбалсан хот ОХУ-тай төмөр замаар холбогдсон. Тэгвэл Монгол Улсаар дамжин ОХУ цаашилбал Европтой холбогдох хамгийн дөт олон улсын гарц гэж үзэж болно...

нийт 1100 км зам туулна. Энэ нь Тяньжингийн боомт хүртэлх зайнаас 863 км, Далианы боомт хүртэлх зайнаас 1163 км-ээр тус тус ойрхон гэсэн эдийн засгийн урьдчилсан тооцоолол гарсан. Жинжоу боомтын талаар танилцуулахад, тус боомт жилд 100 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадал бүхий 24 зогсоолтой, орчин үеийн техник хэрэгсэлээр бүрэн тоноглогдсон, улмаар чанарын шаардлага бүрэн хангасан, хямд, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэг. Ер нь цаашдаа чингэлгээр, задгайгаар болон шингэн ачааг тээвэрлэнэ. Эхний ээлжинд зөвхөн шатамхай бодис болон шингэн ачааг тээвэрлэх юм. Тяньжинтэй өрсөлдөхүйц үнийн тариф гаргахын тулд боомтын захиргаанаас хөнгөлөлттэй үнийн тарифыг хүссэн байгаа. Жинжоу боомтоос Өвөрмонголын Шилийн гол аймгийн Зүүн хатавч гэх боомт хүртэл төмөр

маний бие эхний ээлжинд төлөөлөгчөөр томилогдлоо. Мэдээж цаашдаа үйл ажиллагаа өргөжөөд, ажил ундраад эхлэхээр өргөтгөх асуудал яригдах байх. Хөлөг онгоцны бүртгэлийн компани байгуулах талаар судлаарай гэсэн үүрэг надад өгсөн. Илүү тодорхой мэдээлэл алга. Албан ёсоор бичиг баримтаа авчихсан учраас төлөөлөгчийн ажил эхэлчихсэн. Одоогоор ачаа эргэлт алга байна. Гэхдээ боомтыг танилцуулах, хоёр улсын хооронд мэдээлэл солилцох ажил хийгдэж эхэлсэн байгаа. Эхний ээлжинд 10-20 мянган тонн шингэн нефтийг зургадугаар сардаа багтаагаад тээвэрлэж эхэлнэ гэсэн яриа хэлцэл явж байна. Нарийн тов гараагүй байна.

Монгол Улсын хувьд далайд гарах нэгэн шинэ гарцаа нээж байна гэж би хувьдаа хараад байна. Европын зах зээлд гарах боломж бүрдэж байна уу?

шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, үүний тулд "Нэг бүс нэг зам" стратегийн төлөвлөгөөтэй уялдуулан Монгол, Орос, Хятад гурван улсыг холбосон эдийн засгийн коридорыг бий болгоно. Мөн Ляонин- Монгол-Европын баруун шугам буюу олон улсын тэнгис болон хуурай замд түшиглэсэн ерөнхий шугамыг бий болгож, улмаар Жинжоу боомтоор дамжин Зүүн хатавч-Чойбалсан-Борзя гэсэн маршрутаар Европтой холбох талаар ажиллаж байна" хэмээн дурьдсан байна лээ. Тиймээс манай талаас ч гэсэн энэ асуудлыг дэмжиж ажил хэрэг болгох талаас ажиллах байх гэж харж байна. Өмнөд хөршийн хувьд энэ боомтыг стратегийн чухал ач холбогдолтой гэж тооцож байгаа учраас Монгол, Хятад хоёр орныг холбосон шинэ шугам, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон хоёр орны худалдаа, эдийн засгийн

зам тавигдчихсан. Сүхбаатар аймгийн Бичигтийн боомт хүртэл гэсэн үг л дээ. Тэгэхээр Манайх Сүхбаатар аймгийн төвөөс Бичигтийн боомт хүртэлх дэд бүтцээ бүрэн шийдчихвэл асар хямдхан үнээр далайд гарах гарцаа нээчихлээ гэсэн үг. Жинжоу боомтоос гараад Өвөрмонголын нутгаар яваад Эрээний боомтоор орж ирэхээр харьцангуй өндөр буюу Тяньжин боомтын үнээс тодорхой хэмжээгээр өндөр байгаа юм. Тиймээс Бичигтийн боомтоор дамжуулах гарцыг л хайж байна. Ачаа эргэлтийг татах үүднээс хямдралтай, хөнгөлттэй үнэ тариф гаргаж өгөөч гэсэн хүсэлтийг тавьж, улмаар талууд судалж байгаа юм билээ. Үнэ тарифаа эцэслэж тохироогүй байна. Алсдаа энэ боомт Сүхбаатар, Чойбалсан, Хэнтий гэсэн зүүн аймгуудтай хамгийн ойрхон далайн гарц болно. Бичигтээр орж болно. Дорнодоор орж ирсэн ч зардал хэмнэнэ гэсэн тооцоо хийгээд байгаа юм.

Төлөөлөгчийн газар хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байх вэ?

-Далайн захиргааны ложистик хариуцсан мэргэжилтэн гэдэг утгаараа

-Тантай мэдээж санал нэг байна. Гэхдээ шууд ажил хэрэг болчихсон, өнөө маргаашгүй гарах гэж байгаа асуудал биш.

Энэ бол Зам тээврийн яам, цаашлаад Засгийн газрын төвшинд яригдаж, шийдэгдэх бодлогын асуудал. Миний хувьд зөвхөн хоёр улсын тээвэрлэлтийн асуудалд төлөөлөгчөөр ажиллах үүрэгтэй хүн. Чойбалсан хот ОХУ-тай төмөр замаар холбогдсон. Тэгвэл Монгол Улсаар дамжин ОХУ цаашилбал Европтой холбогдох хамгийн дөт олон улсын гарц гэж үзэж болно. Нэг зүйлийг онцолж хэлэхэд, далайд гарах гарц шинээр нээж буй энэ ажил бол гурван улсын Төрийн тэргүүн нарын уулзалтын хүрээнд яригдсан стратегийн түншлэлийг гүнзгийрүүлэх бодлоготой уялдаж байгаа юм. Тиймээс Ляонин мужийн 2015 оны Засгийн газрын тайландаа "Ляонин муж нь нээлттэй

хамтын ажиллагааны хурдцыг нэмэгдүүлэхэд нөлөөлнө гэж итгэж байгаа.

Тун удахгүй Жинжоу боомтын төлөөлөгчид Монголд ирж Зам тээврийн яамтай боомтын хөгжил, далайд гарах шинэ гарцын талаар яриа хэлцэл өрнүүлнэ гэсэн. Хэдэн хүний бүрэлдэхүүнтэй ирж, яг ямар асуудлыг шийдэх юм бол?

-Ирэх даваа гарагт /өнөөдөр/ төлөөлөгчид ирнэ. Өвөрмонголын Шилийн гол аймгийн төлөөлөгчид, мөн Жинжоу боомтын дэд дарга, хэлтсийн дарга, чингэлэг харууцсан тээврийн захирал гэсэн гурван хүний бүрэлдэхүүнтэй нийтдээ 10 хүн ирэх юм. Зам тээврийн яамны урилгаар ирж байгаа юм. 13-18-ны хооронд хуралдаж боомтын ачаа тээвэрлэлт, Шилийн гол аймгаар дамжих асуудлыг ярилцах юм.

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст шаардлагатай тавилга, эд хогшил- ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй

Үнийн санал авах баримт бичгийг бичгээр хүсэлтэй гаргаж эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50.000 /тавин мянга/ төгрөгөөр худалдан авч болно.

Төлбөрийг Нийгмийн даатгалын хэлтэст бэлнээр тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн дотор хүчинтэй байна

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2016 оны 06 сарын 14-ны өдөр 09:00 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2016 оны 06 сарын 14-ны өдрийн 10:00 цаг -т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх:
Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад тэдээллийг доорх хаягаар авч болно.

УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ ДҮҮРЭГ, 2-Р ХОРОО, ХУУЛЬЧДЫН ГУДАМЖ, ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОМПАНИ ОНӨААТҮГ-ЫН БАЙР, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА МЭРГЭЖИЛТЭН Г.АРИУНЗАЯА УТАС:7023-2788

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016.06.13

Тендер шалгаруулалтын нэр: СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ СУМЫН 3-Р ТОЙРГИЙН ХАТУУ ХУЧИЛГТАЙ АВТОЗАМЫН АЖИЛ

Тендер шалгаруулалтын дугаар: 2016-A007

[Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар] эрх бүхий тендерт оролцогчдоос [СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ СУМЫН 3-Р ТОЙРГИЙН ХАТУУ ХУЧИЛГТАЙ АВТОЗАМЫН АЖИЛ]-ыг гүйцэтгэх тухай бигүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байх.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн дүн санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байх.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2014, 2015 он/

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй.

Эргэн төлөгдөх нөхцөлтэй.

Тендерийн хамт 50,000,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.meps.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (Ахлах мэргэжилтэн Ч.Багболд, Утас:96510404, 70518123)

Тендерийг [2016 оны 07 дүгээр сарын 18-ны 14 цаг 00 минут]-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [2016 оны 07 дүгээр сарын 18]-ны өдрийн, [14 цаг 30 минут] -т нээнэ.

Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авах боломжгүй.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй
Дотоодны давуу эрх тооцоно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад тэдээллийг доорх хаягаар авч болно.

[СҮХБААТАР АЙМАГ, БАРУУН-УРТ СУМ, 7-Р БАГ НУТГИЙН УДИРДЛАГЫН ОРДОН 3-Н ДАВХАР, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА 306 ТООТ ӨРӨӨ (АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ч.БАТБОЛД, УТАС:96510404)]

НЭГ СЭДВЭЭР

ММ-ИЙН ТОДРУУЛГА

А.ТЭГШЖАРГАЛ: 1072 ХУВЬЦАА ҮНДЭСНИЙ ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ ТӨВӨӨР ДАМЖИНА



Г.ГЭРЭЛЦЭНЭГ

“ЭрдэнэТавантолгой” ХК дахь өөрийн эзэмшлийн хувьцаагаа худалдах хүсэлт гаргасан иргэний эзэмшигч байгаа 1072 хувьцааны 30 хувьтай тэнцэх буюу 323 ширхэг хувьцааг нэрлэсэн үнээр нь иргэдээс худалдаж авах шийдвэрийг Засгийн газар гаргасантай холбогдуулан Үндэсний цахим гүйлгээний төвийн захирал А.Тэгшжаргалаас зарим зүйлийг тодрууллаа.

САЙД ЯРЬЖ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРТУУЖИНИ

-1072 ширхэг хувьцааны 30 хувь буюу 323 ширхэг хувьцааг Засгийн газар банкаар дамжуулан иргэдээс худалдан авахаар боллоо?

Тиймээ. Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 311 тоот тогтоолын дагуу “Эрдэнэ таван толгой” ХК-ийн өөрийн эзэмшлийн хувьцааныхаа 30 хувийг Монгол улсын Засгийн газарт худалдах боломжтой болсон. Энэ ажлын хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан бүртгэл хийгдэх бөгөөд банкууд иргэдийн хүсэлтийг манай төвийн сүлжээгээр дамжуулан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ)-ийн системд бүртгүүлнэ. ҮЦТХТ-өөс хувьцаа худалдах шийдвэр гаргасан иргэдийн данс руу нэгдсэн сүлжээгээр дамжин гүйлгээ хийгдэнэ гэсэн үг.

-Үндэсний цахим гүйлгээний төвийн оролцооны талаар тодруулаар байна?

Манай төв нь 2012 оны 10 сараас эхлэн Хүний хөгжил сангаас олгож байгаа хүүхдийн мөнгийг сар бүр дамжуулж ирсэн. Сангийн яамнаас батлагдсан санхүүжилт болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар (НХҮЕГ)-аас ирүүлсэн хүүхдийн мөнгө авагчийн цахим мэдээллийг үндэслэн банкинд байршиж байгаа хүүхдийн мөнгө авагчийн дансанд гүйлгээг дамжуулдаг. Яг энэ зарчмаар ҮЦТХТ-өөс ирсэн

...Үндэсний цахим гүйлгээний төв байгуулагдснаар банкуудын төв салбар, Сангийн яамны Төрийн сангийн газар, Арилжааны төлбөр тооцооны төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ)-ийг холбосон дундын сүлжээгээр дамжуулан банк хоорондын төлбөр тооцоог бодит цагийн горимоор дамжуулж эхэлсэн...

мэдээллийн үндэслэн иргэдэд хувьцааны мөнгийг харилцдаг банкаар нь дамжуулан байршуулна.

-Тэгэхээр танай төв нь улсын хэмжээний бүх гүйлгээг дамжуулдаг гэсэн үг үү?

Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) нь Монгол Улсын хэмжээнд банк хоорондын төлбөр тооцооны үйлчилгээг түргэн, шуурхай, найдвартай гүйцэтгэх, төлбөрийн системийн оролцогчийн нэвтрүүлж буй бэлэн бус төлбөр тооцооны шинэ хэрэгслийг банк хоорондын төлбөр тооцоонд ашиглах, төлбөр тооцоотой холбоотойгоор үүсч болох эрсдэлийг хязгаарлах, бууруулах боломжийг бүрдүүлэх зорилготой. Үндэсний цахим гүйлгээний төв байгуулагдснаар банкуудын төв салбар, Сангийн яамны Төрийн сангийн газар, Арилжааны төлбөр тооцооны төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ)-ийг холбосон дундын сүлжээгээр дамжуулан банк хоорондын төлбөр тооцоог бодит цагийн горимоор дамжуулж эхэлсэн.

-Картын үйлчилгээг бас танайх харьцдаг уу?

Үндэсний цахим гүйлгээний төв нь 2010 оны 5 дугаар сараас эхэлж бүх карт гаргагч банктай хамтран “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-г байгуулж, тухайн банкны карт эзэмшигч аль ч банкаар үйлчлүүлэх боломжийг нээж, төлбөрийн картын үйлчилгээг 24 цагаар тасралтгүй үзүүлэх болсон нь бэлэн бус төлбөр тооцоог дэмжиж, картын хэрэглээ өсөн нэмэгдэх хөшүүрэг болсон юм.

С.ЭРДЭНЭ: 1072 ХУВЬЦААНЫ 30 ХУВИЙГ ХУДАЛДАЖ АВАХ АСУУДАЛ СОНГУУЛЬТАЙ ЯМАР Ч ХАМААГҮЙ

Б.ДАВААХҮҮ

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэтэй 1072 хувьцааны асуудлаар ярилцлаа.

-Засгийн газраас 1072 ширхэг хувьцааны 30 хувийг худалдаж авахаар болсон. Энэ талаар тодруулаач?

Монгол Улсын Засгийн газрын эзлэгчтэй бусхуралдаанаар Эрдэнийн хувь буюу 1072 ширхэг хувьцааны 30 хувийг тухайн иргэн өөрөө хүссэн тохиолдолд Засгийн газар өөрийн хөрөнгөөр худалдан авах, дараа нь хувьцааны үнэ өссөн тохиолдолд анх худалдсан үнээрээ буцаан худалдаж авч болдог байх тогтоол шийдвэрийг гаргалаа. Энэ ажлыг зохион байгуулах үүрэг Сангийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд ногдсон байгаа. Тиймээс дээрх ажлыг манай Нийгмийн халамж, үйлчилгээний Ерөнхий газар зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа орсон байна. Хувьцааныхаа 30 хувийг зарах хүсэлтэй иргэд нийслэл хот болон орон нутагт арилжааны банкинд өөрийн биеэр очиж, тодорхой маягт бөглөх замаар арилжааны төвийн гаргасан маягтыг бөглөж, өөрийн гарын үсгээ зурж өгснөөр иргэний хийх ажил болно. Үүний дагуу Нийгмийн халамж, үйлчилгээний Ерөнхий газар арилжааны банкууд болон Монголбанкт хамтран хүүхдийн мөнгө олгодог зарчмаар бүх тулгалтуудыг хийж, эргэд Монголбанкар дамжуулан иргэдийн дансанд мөнгийг хийх маягаар асуудлыг

шийдвэрлэх юм. Мөнгөн дүнгийн хувьд нэг сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй хувьцааны 30 хувь 300 мянган төгрөг байгаа. Энэ үйл ажиллагаа Засгийн газрын тогтоолыг дагаж гарсан журмын дагуу энэ долоо хоногос улс орон даяар хэрэгжиж эхэлнэ. Иргэн өргөдлөө өгснөөс хойш долоо хоногийн дараа тухайн иргэний дансанд хувьцааны 30 хувьтай тэнцэх хэмжээний мөнгө орж эхлэх юм.

-Хэдий хугацаанд мөнгө иргэдийн дансанд байрших вэ?

Иргэд өргөдлөө өгснөөс хойш долоо хоногийн дараа тухайн иргэний өөрийн дансанд хувьцааны мөнгө нь орно. Улсын хэмжээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудыг хасаад нийтдээ 1.6 сая иргэн хувьцаанаасаа зараагүй байгаа. Тэдгээр иргэдийн хэмжээнд эрх нь үүснэ гэж ойлгож болно.

-Арилжааны банкинд очихдоо иргэн ямар бичиг баримтыг бүрдүүлж очих вэ?

Арилжааны банкинд очихдоо иргэн иргэний үнэмлэхээ авч очих, тогтсон үнэт цаасны төвлөрсөн тооцоо арилжааны төвийн гаргасан маягтыг бөглөж, өөрийн гарын үсгээ зурж өгснөөр иргэний хийх ажил болно. Цаашдаа Монголбанкар дамжиж, нийслэлийн Халамж үйлчилгээний ерөнхий газрын холбогдох хүмүүс иргэдийн мэдээллийг нягталж тулгасны дараа эрх бүхий иргэдийн мөнгө арилжааны банкаар дамжин дансанд нь орох юм. Түүнчлэн, хувьцааны 30

хувьтай тэнцэхүйц 300 мянган төгрөг зуу, зуун мянгаар гурав хуваагдан иргэдийн дансанд орно. Иргэд өөрт ойр байрлах Үүнээс гадна хувьцааны ханш өссөн тохиолдолд иргэд худалдан авсан үнээрээ хувьцаагаа буцаан худалдан авах боломжтой.

-Ерөнхий сайд Ч.Сайханбилэг зуу зуун мянгаар нь хувааж дансанд нь хийнэ гэж мэдэгдсэн байсан?

Хувьцааны 30 хувьтай тэнцэх 300 мянган төгрөгийг иргэдийн дансанд зуу, зуун мянгаар нь хувааж хийх нөхцөл тавигдсан байгаа. Мөнгө бүтэн дүнгээрээ шийдэгдэнэ. Тэгэхээр эхэлж хүсэлт гаргасан нь мөнгөө авч, сүүлийнх нь хувьцаагаа зарах боломжгүй үлдэнэ гэсэн асуудал байхгүй. Иргэд мөнгөө бүрэн авч дуусах хугацааг тодорхойлох боломжгүй. Энэ мөн сонгуультай ямар ч хамаагүй. Сонгууль болдогоороо болно.

-Засгийн газар хувьцааг худалдаж авах асуудлыг дөрөв, дөрвөн жилийн хугацаатай шийдээд байх шиг. Бусад аж ахуйн нэгж иргэдээс хувьцааг худалдаж авья гэхээр үнэт цаас хэлбэрт ороогүй боломжгүй гэдэг. Гэтэл Засгийн газар худалдаж авч болох юм уу?

Үүнд хоёр шалтгаан бий. Иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах үүднээс 1072 ширхэг хувьцааг хөрөнгийн биржийн эргэлтэд оруулаагүй байгаа. 2012-2016 он хүртэлх өнгөрсөн дөрвөн жилийн хугацааны үйл ажиллагааны мөрний хөтөлбөрт 1072 ширхэг хувьцааг эдийн засгийн зөв эргэлтэд оруулах

талаар тусгагдсан. Энэ дагуу Засгийн газар ажлаа явуулж байна. Хоёрдугаарт, нэрлэсэн үнээр Засгийн газар худалдаж аваад эргээд шаардлагатай тохиолдолд буцааж худалдах боломжтой байгаа. Аж ахуйн нэгж хувьцааг худалдан авсан тохиолдолд ийм боломж байхгүй. Авсан л бол буцааж худалдахгүй шүү дээ. Засгийн газар эхлээд хувьцааны 30 хувийг худалдаж аваад дараа нь 70 хувийг худалдаж авах ажлыг зохион байгуулахаар болсон. Гэхдээ хувьцааны үнэ өссөн тохиолдолд иргэд хувьцаагаа буцаан худалдан авч, өөр арилжаанд оруулах боломжтой байх зохицуулалтуудыг хийж байгаа. Өнөөдөр 1072 хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах бодит нөхцөл бүрдсэн. Өмнө нь инфляци өндөр хувьтай байсан. Харин өнөөдөр инфляци хоёр хувьтай, эдийн засгийн өсөлт 3.1 хувьтай байна. Ийм тааламжтай нөхцөлд эдийн засагт бэлэн мөнгөний нийлүүлэлт хийхэд эрсдэл бага гэж үзсэн учраас энэ алхмыг хийж байгаа.

-Төсөв хүнд байгааг бүгд мэднэ. Санхүүгийн эх үүсвэр нэг л тодорхойгүй харагдаад байх юм?

Засгийн газарт дотоодын бонд гаргах эрх нь нээлтэй байгаа. Автозам, төмөр зам, эрчим хүчний чиглэлээр гаргаж байгаа бонд, авч буй эзэлийг өрийн хэмжээнд тооцохгүй байхаар шийдвэрлэсэн. Тиймээс энэ хүрээнд яригдаж байгаа асуудал. Эх үүсвэрийг дотоодын бонд гаргах замаар шийдвэрлэнэ. Эрх үүргийнхээ хүрээнд Сангийн яам шийдээд явна.

“Эрдэнэ таван толгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын Засгийн газарт худалдах хүсэлтээ гаргаарай

Нэгдүгээр алхам:

www.schcd.mn сайтад хандаж, “Эрдэнэ тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч эсэхээ, Төвлөрсөн хадгаламжинд данстай эсэхээ шалгах гэсэн хэсгийг дарна. Улмаар хайлт хэсэгт регистрийн дугаараа оруулахад тухайн иргэнд хэчнээн хэмжээний хувьцаа байгаа эсэх талаарх мэдээлэл гарч ирнэ.

Хоёрдугаар алхам:

Дурын арилжааны банкинд иргэний үнэмлэхтэйгээ очиж үйлчлүүлнэ

Гуравдугаар алхам:

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн гаргасан тусгай маягтыг үнэн зөв бөглөж, гарын үсгээр баталгаажуулна.

Жич: Насанд хүрээгүй иргэд хувьцаагаа 18 нас хүрсэн хойноо захиран зарцуулах эрхтэй.

ДЭЛХИЙ

Ким Жон Ун кимчиний үйлдвэр байгуулжээ

Хойд Солонгос улсын залуу удирдагч Ким Жон Уны ивээл дор “Дэлхийн эрүүл мэндэд тустай таван гол хүнсний нэг” гэж нэрлэгддэг кимчиний үйлдвэр шинээр баригджээ. Ким Жон Ун Пхеньяны иргэдийн хоол хүнсэнд хэрэглэгдэх жилийн кимчиний хэрэглээг хангах зорилготойгоор баригдсан шинэхэн үйлдвэрийн нөхцөл байдалтай бичлэн танилцсан байна. Үйлдвэрийн тухайд

жилдээ 4200 тонн кимчи үйлдвэрлэх хүчин чадалтай аж. KCNA агентлагийн мэдээлж буйгаар Ким Жон Ун цаашдаа үйлдвэрийн хүчин чадлыг улам өргөжүүлж, хойд солонгосчуудын бүгдийнх нь кимчиний хэрэглээг хангахуйц үйлдвэр болгох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд уг үйлдвэрийг үлгэр болгож, дараа дараагийн үйлдвэрийг барихыг холбогдох албаныханд даалгасан ажээ. Мөн Ким

“Кимчи бол солонгосчуудын хамгийн дуртай үндэсний хоол. Дэлхийн эрүүл мэндэд тустай таван гол хүнсний нэг гэдгээрээ танигдсан хоол” хэмээн магтсанаа гадна “Гэртээ иддэгээс ч илүү амттай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Пхеньяны ард иргэдийг дэлхийн хамгийн амттай хоолоор хангаарай” хэмээн үйлдвэрийн ажилтнуудаас хүссэн байна.



Эйр Францынхан АЖИЛ ХАЯЛАА

Хөлбөмбөгийн Европын аварга шалгаруулах “Евро-2016” наадмын нээлт энэ сарын 10-ны өдөр хөдөлмөрийн хуулийн шинэчлэлийг эсэргүүцсэн жагсаал цуглан үргэлжилж буй Франц улсад болсон билээ. Тэгвэл өнгөрөгч бямба гаргаас эхлэн орон нутгийн иргэний агаарын тээврийн Эйр Франц компаниийн нисгэгчид ажил хаяж, улс орны өнцөг булан бүрээс хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг үзэхээр ирсэн фанатуудыг хохироож магадгүй нөхцөл байдал үүсчээ. Тус улсад хөдөлмөрийн хуулийн шинэчлэсэн найруулгыг эсэргүүцэх жагсаал цуглаан хэдэн долоо хоногийн өмнөөс эхэлсэн байдаг. Энэ хүрээнд төмөр замын ажилтнууд 10 хоногийн турш ажил хаяж, үүний улмаас дотоод дахь замын хөдөлгөөнд эмх замбараагүй байдал үүсчээ. Тэр бүү хэл террорист халдлага гарч болзошгүй гэсэн олонхоомжлол, Парис эзрэг болон хотуудад нүүрлэсэн үерийн гамшиг ч нэг сарын турш зохион яриуулагдах Европын зарга шалгаруулах хөлбөмбөгийн тэмцээнд саад учруулж болзошгүй байсан юм.

БОЛИВИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ НУУЦ ХҮҮТЭЙ ЮУ



Б.ДАВАА

Өмнөд Америкийн Боливи улсын Ерөнхийлөгч 56 настай Эво Моралес нууц хүүтэй гэх мэдээлэл орон нутгийн сайтуудаар цацагдаж болжээ. Тэгвэл уг үйл явдал зохион байгуулалттай гүтгэлэг байсан, уг хэрэгт холбогдуулан таван хүнийг баривчилсан талаар албаныхан олон нийтэд мэдээлсэн байна. Тодруулбал, хэсэг бүлэг этгээдүүд тодорхой зорилгын улмаас савангийн дуурь шиг цуурхлыг зохиомжилж, нэгэн гэр бүлд их хэмжээний мөнгө төлөн хүүг нь Эво Моралесын хүү мэт дүр эсгэхийг даалгасан хэрэг гарсан ажээ. Мөн хэлсэнээр нь хийвэл сургалтын төлбөрийг нь төлж, газар худалдан авч өгнө хэмээн амласан байсан гэнэ. Мөн гэр бүлд нь 15 мянган ам.доллар төлөхөөр тохиролцсон байсныг хууль хяналтынхан тогтоожээ. Одоогоор баривчлагдаад буй таван хүн тус гэмт хэргийг ямар шалтгаанаар үйлдсэнийг хараахан тодорхой болгоогүй байгаа юм. Ямартай ч, эдүгээ Моралесын

нууц хүүтэй холбоотой асуудал нийтийн анхаарлыг татаад буй аж. Сэжигтнүүд хэн болох талаархи мэдээлэл мөн нууцлагдмал байна. Гэхдээ Ерөнхийлөгчийн экс найз бүсгүй Габриэла Запатагийн ойрын хүмүүс байсан гэх албан бус мэдээлэл байгаа юм. Мөрдөн

байцаах албаныхны мэдээлснээр ганц бие Ерөнхийлөгч хуучин найз бүсгүй Габриэла Запатагай хамтран амьдарч байхдаа нэг хүүтэй болж байсан ч, 2009 онд хүү нь зуурдаар нас барж байжээ. Боливиын уугуул иргэдээс гаралтай анхны Ерөнхийлөгч

гэгддэг Моралес ч хүүтэй болж байсан гэдгээ баталсан ч, төрөөд удалгүй нас барсан хэмээн мэдэгдсэн байна. Харин Запата бүсгүй өмнө нь хүүгээ амьд гэдгийг тодотгож байсан ч, сүүлийн үед уг мэдээллээ өөрчлөх болжээ. Запата Хятадын инженерийн

Мухаммед Алиг төрөлх хотод нь нутаглууллаа

Америкийн домогт боксчин Мухаммад Алиг баасан гарагт төрөлх нутаг болох АНУ-ын Кентукки муж улсын Луисвилл хотод нь оршуулжээ. “Агуу” хэмээх хочит мэргэжлийн боксын домог болсон тамирчин Мухаммед Алиг эцсийн замд нь үдэх оршуулгын ёслол өнгөрсөн баасан гарагт боллоо. Мэргэжлийн боксын рингэнд гурван ч удаа дэлхийн аваргын бүсийг зүүж байсан анхны тамирчин гэгддэг тэрээр өнгөрсөн долоо

хоногийн пүрэг гарагт өвчний учир 74 насандаа таалал төгссөн юм. Түүнийг эцсийн замд нь үдэх ёслол төрсөн нутаг болох Кентакигийн эрх чөлөөний танхимд зохион байгуулагдаж, домогт тамирчны гэр бүл үр хүүхэд, мянга мянган шүтэн бишрэгчид нь оршож, мусалман шашны ёс жаягийн дагуу оршуулгын ёслолыг үйлджээ. Ёслолд түүнийг бэлбэсэн эхнэр болон дөрөв дэх эхнэр нь болох Лонне Лайла, Ханна гэх охидуудаа дагуулан ирснээс гадна

Сидней гэх зээ охин нь ч мөн хүрэлцэн ирсэн байжээ. Мөн хоёр дахь эхнэр Халлилах Камачо Али, гурав дахь эхнэр Вероника Порче Али нар ч хүрэлцэн ирсэн байжээ. Энэ мэтээр Мухаммед Алиг нутаглуулах ёслолын үйлдвэрлэл мусалман шашны дагуу хоёр өдрийн турш явагдсан бөгөөд өнөөдрийн үйл ажиллагаанд 14 мянган хүн ирсэн гэсэн мэдээлэл байна. Харин Алигийн анхны эхнэр Сонжи Рой 2005 онд таалал төгссөн байдаг билээ.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

Доорх жагсаалтад нэр дурдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид Та бүхэн хүснэгтэд заасан хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйл болон 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу төлбөрөө хугацаанд нь бүрэн төлж бүртгүүлэхийг мэдэгдэе.

| № | Код | Эзэмшигч | Талбай (га) | Олгосон огноо |
|----|-----------|-------------------------------------|-------------|---------------|
| 1 | XV-013771 | Хааншугат | 1053.28 | 2008.06.02 |
| 2 | MV-018461 | Монголзадун фашкоэн | 2626.06 | 2015.06.02 |
| 3 | MV-013766 | Эй Эл Жи Ти | 111.52 | 2008.06.02 |
| 4 | XV-018407 | Хос-Орчлон | 1169.6 | 2015.06.02 |
| 5 | XV-018530 | Баялаг эрдэс цогт | 26468.65 | 2015.06.02 |
| 6 | XV-013903 | Зууны төгөл | 987.59 | 2008.07.21 |
| 7 | MV-018830 | Өгөөмөрбаян хайрхан | 856.84 | 2015.06.02 |
| 8 | XV-018266 | Орд ундарга | 1098.46 | 2015.06.02 |
| 9 | XV-018313 | Вайдцстеп | 594.26 | 2015.06.03 |
| 10 | MV-017321 | Эм Кой Эм Эн майнинг | 5562.73 | 2013.06.03 |
| 11 | XV-018375 | Эн Си Ар | 738.31 | 2015.06.04 |
| 12 | MV-013784 | Эдлт гурван багана | 51.41 | 2008.06.04 |
| 13 | XV-018433 | Зосол-Уул | 7387.76 | 2015.06.04 |
| 14 | XV-018511 | Монголзадун фашкоэн | 3690.25 | 2015.06.04 |
| 15 | MV-017059 | Миншингэрэлт од | 106.44 | 2012.06.04 |
| 16 | XV-018069 | Дорнын хавцал тал | 23867.93 | 2015.06.05 |
| 17 | MV-017325 | Би Би Жи Эн | 133.12 | 2013.06.05 |
| 18 | MV-011810 | Ордсөрейд | 97.77 | 2006.06.05 |
| 19 | MV-005874 | Бүүргэнт | 94.01 | 2003.06.05 |
| 20 | XV-017936 | Баганагтримкон | 1594.53 | 2015.06.05 |
| 21 | XV-017960 | Баянчулуут газар | 592.03 | 2015.06.05 |
| 22 | XV-018336 | Эрдэмтмонгол | 694.6 | 2015.06.05 |
| 23 | MV-005881 | Тушиг Индустраль | 110.53 | 2003.06.06 |
| 24 | XV-015043 | Саруулсайн | 11371.77 | 2009.08.03 |
| 25 | XV-018378 | Сатирем | 5179.95 | 2015.06.08 |
| 26 | XV-017674 | Шохойтууруу | 986.53 | 2005.06.08 |
| 27 | XV-018376 | Глобал майнинг менежмент консалтинг | 2155.16 | 2015.06.08 |
| 28 | XV-009953 | Шохойтууруу | 1601.65 | 2005.06.08 |
| 29 | MV-018898 | Олзаниг | 263.97 | 2015.06.08 |
| 30 | MV-017551 | Ли Эн майнинг | 4455.27 | 2015.06.08 |
| 31 | XV-009965 | Буман-Олз | 3142 | 2005.06.08 |
| 32 | MV-015590 | Арвижжамандал | 673.41 | 2010.06.08 |
| 33 | MV-018899 | Нутгийн-орд | 260.66 | 2015.06.08 |
| 34 | XV-018755 | Эрдэмтмонгол | 857 | 2015.06.08 |
| 35 | XV-018440 | Будар минералс | 4079.49 | 2015.06.09 |
| 36 | XV-018430 | Чандмань минералс | 5733.4 | 2015.06.09 |
| 37 | XV-018356 | Эс И И Дн | 3759.1 | 2015.06.09 |
| 38 | MV-017551 | Дорнын чулуулаг | 1505.36 | 2014.06.09 |
| 39 | MV-016700 | АУМ | 148.45 | 1995.06.09 |
| 40 | XV-018490 | Чандмань минералс | 1834.2 | 2015.06.09 |
| 41 | XV-018414 | Эс-Арашан | 1691.65 | 2015.06.09 |
| 42 | XV-018462 | Брайбээр дрислинг | 2187.71 | 2015.06.09 |
| 43 | XV-018540 | Глобалвалло майнинг | 12228.79 | 2015.06.09 |
| 44 | MV-001121 | Улз гол | 112.64 | 1995.06.09 |
| 45 | XV-018574 | Эм Би Би Си | 996.18 | 2015.06.09 |
| 46 | MV-009978 | Ариун-Өрвөх | 41.75 | 2005.06.09 |
| 47 | MV-016844 | Тогосцүлтэм | 176.71 | 2011.06.09 |
| 48 | MV-000362 | Аум алт ХХК | 730.51 | 1995.06.09 |
| 49 | MV-016843 | Ширээгийн шугуй | 122.3 | 2011.06.09 |
| 50 | MV-000400 | Жамп-Алт | 103.47 | 1995.06.09 |
| 51 | XV-016977 | Ди Эйч Ни | 571.3 | 2008.06.09 |
| 52 | MV-011114 | Жамп | 72.05 | 1995.06.09 |
| 53 | MV-000286 | Улз гол | 224.99 | 1995.06.09 |
| 54 | MV-009975 | Молшметал | 79.61 | 2005.06.09 |
| 55 | MV-007687 | Гацуурт | 1146.36 | 2004.06.10 |
| 56 | MV-007690 | Гацуурт | 88.14 | 2004.06.10 |
| 57 | XV-007685 | Эмээлтмайнг | 7250.29 | 2004.06.10 |
| 58 | MV-007688 | Гацуурт | 1220.47 | 2004.06.10 |
| 59 | MV-007689 | Гацуурт | 284.31 | 2004.06.10 |
| 60 | XV-007674 | Бакуд майнинг | 5026.87 | 2004.06.10 |
| 61 | MV-007700 | Нарийн гол гууд | 376.4 | 2004.06.10 |
| 62 | MV-007716 | Монгол-Анар трейд | 25.05 | 2004.06.11 |
| 63 | XV-018282 | ДУО | 3921.92 | 2015.06.11 |
| 64 | XV-018374 | Эм Ай Эй | 2086.22 | 2015.06.11 |
| 65 | XV-018483 | ГеоБурд | 3436.82 | 2015.06.11 |
| 66 | MV-014981 | Орчлон айрон | 40.52 | 2004.06.11 |
| 67 | XV-012483 | Пибодивинсэй ресорсез | 22071.01 | 2002.06.11 |

| | | | | |
|-----|-----------|---------------------------------|----------|------------|
| 68 | XV-017163 | Цагаан-Өвөлжөө | 201.33 | 2002.06.11 |
| 69 | XV-013780 | Цагаан-Өвөлжөө | 7714.78 | 2002.06.11 |
| 70 | MV-000231 | Гурвангохм | 73.79 | 1997.06.12 |
| 71 | MV-017108 | Ирмүүнбосго | 9.45 | 1997.06.12 |
| 72 | MV-015458 | Тувшингор трейд | 156.22 | 1997.06.12 |
| 73 | MV-000436 | Ирмүүнбосго | 22.23 | 1997.06.12 |
| 74 | MV-018916 | Нью коже | 32014.45 | 2015.06.12 |
| 75 | MV-018915 | Нью коже | 18913.05 | 2015.06.12 |
| 76 | MV-018914 | Нью коже | 2464.93 | 2015.06.12 |
| 77 | MV-000382 | Гурвангамга | 40.71 | 1997.06.12 |
| 78 | MV-003389 | Баянгэгэй импекс | 32.99 | 2001.06.12 |
| 79 | XV-018490 | Лукрий | 9592.99 | 2007.06.13 |
| 80 | XV-014891 | Лукрий | 5680.17 | 2007.06.13 |
| 81 | MV-000104 | Монгэнгэр | 81.37 | 1997.06.13 |
| 82 | MV-000435 | Бэрлэжмайнинг | 493.52 | 1997.06.13 |
| 83 | MV-000194 | Губилгөй трейд | 359.31 | 1997.06.13 |
| 84 | XV-014889 | Лукрий | 32556.77 | 2007.06.13 |
| 85 | MV-012500 | МБПЦ | 17.75 | 2007.06.14 |
| 86 | XV-018431 | Эол-Ач | 545.64 | 2015.06.15 |
| 87 | XV-018741 | Домогт хээр | 11248.06 | 2015.06.15 |
| 88 | XV-017950 | АСУМО | 8757.42 | 2015.06.15 |
| 89 | XV-018398 | Ланд-Оре | 10361.17 | 2015.06.15 |
| 90 | XV-020414 | АСУМО | 1497.79 | 2015.06.15 |
| 91 | MV-017664 | Фрийгууд эрин | 3959.69 | 2012.06.15 |
| 92 | XV-018749 | Монголын проект менежмент групп | 2608.88 | 2015.06.15 |
| 93 | XV-018604 | Багдөш | 1975.09 | 2015.06.15 |
| 94 | XV-018561 | Голден гео физик | 10658.04 | 2015.06.15 |
| 95 | XV-018326 | Монжаран | 439.04 | 2015.06.15 |
| 96 | XV-018341 | Монголын-Эгэжкютерс | 688.73 | 2015.06.15 |
| 97 | XV-018358 | АСУМО | 3217.25 | 2015.06.15 |
| 98 | MV-018466 | МОНСКОРП | 409.01 | 2011.06.15 |
| 99 | XV-020413 | АСУМО | 1930.83 | 2015.06.15 |
| 100 | XV-018299 | Ган | 774.6 | 2015.06.15 |
| 101 | XV-020412 | АСУМО | 3806.64 | 2015.06.15 |
| 102 | XV-017824 | Аргод | 57473.32 | 2015.06.15 |
| 103 | XV-018245 | Талсминерал | 9695.62 | 2015.06.15 |
| 104 | MV-007722 | Бичигтхайрхан трейд | 28.92 | 2004.06.15 |
| 105 | XV-018310 | АСУМО | 5059.34 | 2015.06.15 |
| 106 | XV-014930 | Хүслэмж | 2066.9 | 2009.06.15 |
| 107 | XV-017925 | Металл-Олт | 1843.7 | 2015.06.15 |
| 108 | XV-018315 | Хамгагчудконстракши | 4702.98 | 2015.06.16 |
| 109 | XV-017949 | Фокстар интгерэйшл | 4344.29 | 2015.06.16 |
| 110 | XV-018715 | Их хардал | 5062.93 | 2015.06.16 |
| 111 | XV-018600 | Эм Би Би Си | 411.4 | 2015.06.16 |
| 112 | XV-018524 | ТПС андуу | 2010.01 | 2015.06.16 |
| 113 | XV-017913 | Стархолдинг | 1295.95 | 2015.06.16 |
| 114 | XV-018534 | Юг И Ар Ти Си Эф Жи | 8472.33 | 2015.06.16 |
| 115 | XV-018420 | Цагаагчудконстракши | 8900.07 | 2015.06.16 |
| 116 | XV-018587 | Тондраймонд дрислинг | 6650.51 | 2015.06.16 |
| 117 | XV-018639 | Монхмайнинг | 21354.64 | 2015.06.16 |
| 118 | XV-017913 | Пахурирбизнес групп | 14565.22 | 2015.06.16 |
| 119 | XV-018706 | Оюусувдын хиншиг | 586.4 | 2015.06.16 |
| 120 | MV-018925 | Эрдэнэжас | 2354.82 | 2015.06.16 |
| 121 | XV-018621 | Отгонбогд | 3483.01 | 2015.06.16 |
| 122 | XV-014934 | Итгалтушиг | 28.06 | 2009.06.17 |
| 123 | MV-017486 | Дугуй-Уул | 117.11 | 2009.06.17 |
| 124 | MV-013813 | Олоонгол трейд | 77.47 | 2008.06.17 |
| 125 | XV-013809 | Ти энд Пн | 267.91 | 2008.06.17 |
| 126 | MV-001693 | Монголресурсетмент | 54.26 | 1999.06.17 |
| 127 | XV-018533 | Маунтайн шаста | 2407.64 | 2015.06.18 |
| 128 | XV-018319 | Дуут хондиг | 2067.52 | 2015.06.18 |
| 129 | XV-018539 | Ди Эйч Эгт | 6221.24 | 2015.06.18 |
| 130 | XV-018367 | Хонгор эно | 2228.69 | 2015.06.18 |
| 131 | MV-018933 | Погг-Оно | 510.36 | 2015.06.18 |
| 132 | XV-018554 | Монгон нахна | 6119.59 | 2015.06.18 |
| 133 | XV-017904 | Тэргүүмакс | 19800.26 | 2015.06.18 |
| 134 | XV-018315 | Хамгагч монгол хуралдй | 12633.33 | 2015.06.18 |
| 135 | XV-017951 | Ханжигийн хуудр | 3686.12 | 2015.06.18 |
| 136 | XV-018549 | Чингисийн алтан зоос | 1963.95 | 2015.06.18 |
| 137 | MV-015601 | Царилхад | 131.93 | 2010.06.18 |
| 138 | XV-017820 | Баян талст эрдэнэ тур | 10802.6 | 2015.06.18 |
| 139 | | | | |

ШУУРХАЙ МЭДЭЭ

ЦАЛИНГИЙН СУУТГАЛЫГ 50 ХУВИАС

ХЭТРҮҮЛЖ БОЛОХГҮЙ

“School Police” хөтөлбөр зусланд хэрэгжинэ

Н.ЗАЯА

“School police” эргүүлийн хөтөлбөрийг зуслангуудад хэрэгжүүлэхээр болсон байна. Тодруулбал, НИТХ, Улаанбаатар хотын цагдаагийн газар, Нийслэлийн боловсролын газар болон нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн зуслангийн газруудтай хамтран хэрэгжүүлэх гэнэ. Энэхүү хөтөлбөрийг зуны улиралд хүүхдүүдийг гэмт хэрэг, захиргааны зөрчилд өртөх, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд хөрөгжүүлж байгаа аж.

Хөтөлбөрийн хүрээнд “School police” эргүүлийн хөтөлбөрийн ажлын албанаас эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд хэрэглэх хантааз, хэрэглэгдэхүүнүүдийг зуслангийн удирдлагуудад олгох юм байна. Гурав дахь жилдээ хэрэгжиж буй тус хөтөлбөрийн үр дүнд өнгөрсөн жил гэхэд сургууль орчмын гэмт хэрэг 15.3 хувиар буурчээ.

-Цалин хөлснөөс ямар суутгалуудыг хийдэг юм бэ. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Ажил олгогч ажилтны цалин хөлснөөс хэд хэдэн тохиолдлуудад суутгал хийх ёстой байдаг. Хэрвээ тухайн ажилчин ямар нэг алдаа гаргасан эсвэл ямар нэгэн шалтгааны улмаас ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан бол цалингаас нь суутгаж авна. Гэхдээ нэг сарын дундаж цалингаас хэтрэхгүй байх ёстой. Мөн хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасан бусад нөхцөлд цалингаас суутгадаг. Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгалыг тухайн хүний цалин хөлсний 20 хувиас хэтрүүлж болохгүй. Ингэхдээ орлогын албан татварыг оролцуулахгүйгээр суутгана. Харин хүүхдийн тэтгэлэг гаргуулах болон хэд хэдэн суутгал нэгэн зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрүүлж болохгүй гэж хуулиараа зохицуулдаг.

-Зарим тохиолдолд илүү цагаар ажилладаг шүү дээ. Ер нь ямар тохиолдолд илүү цагаар ажиллах ёстой вэ?

-Хуулийн дагуу хөдөлмөрийн дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсан гэж үздэг. Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу

Н.БАТЗАЯА

Цалингийн суутгал, илүү цагаар ажилласан болон ажил хаялттай холбоотой зарим зүйлийн талаар Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн Н.Хүрэлбаатараас тодрууллаа.

хэд хэдэн тохиолдолд илүү цагаар ажиллуулж болно. Тухайлбал, улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх үед илүү цагаар ажиллуулдаг. Мөн байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх тэдгээрийн хор уршгийг нэн даруй арилгахад илүү цагаар ажиллуулна. Түүнчлэн нийтийн усан хангамж, цахилгаан, дулааны эрчим хүч, тээвэр, холбооны хэвийн ажиллагааг алдагдуулсан гэмтлийг арилгах, урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай хийхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэх ёстой тохиолдолд тухайн ажилчныг илүү цагаар ажиллуулж болохоор хуулиараа зохицуулагдсан. Гэхдээ хамтын болон хөдөлмөрийн гэрээнд

тохиролцоогүй бол дээр дурьдсанаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглодог юм. Мөн ажилтныг хоёр ээлжинд дараалан ажиллуулахыг хуулиараа хориглоно.

-Илүү цагаар ажилласан тохиолдолд цалингийн нэмэгдэл авдаг уу. Хуулиараа хэрхэн зохицуулсан байдаг вэ?

-Хэрвээ ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн бол нэмэгдэл хөлс тооцож олгодог. Мөн ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсэн, шонийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно гэж Хөдөлмөрийн тухай хуульд заасан байдаг. Тиймээс илүү цагаар ажилласан л бол тухайн ажилчин нэмгэдэл хөлс авах ёстой.

-Хэдэн төгрөг өгдөг вэ?

-Нэмэгдэл хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль болон Хамтын гэрээгээр тогтоосон хэмжээгээр ажил олгогч ажилтантай тохиролцсоны үндсэн дээр тогтоодог. Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгох ёстой.

-Хүмүүс нэг үеэ бодвол ажил хаялт зарлаж, өөрсдийн эрх ашгийн төлөө тэмцдэг болсон. Ямар тохиолдолд ажил хаях эрхтэй вэ?

-Ажил олгогч хуульд заасан эвлэрүүлэх арга хэмжээнд оролцох үүрэг болон зуучлагчийн оролцоотой тохиролцсон шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд ажил хаялт зарлах эрхтэй. Мөн ажил олгогч хөдөлмөрийн арбитрын зөвлөмжийг хүлээн авч гаргасан шийдвэрээ биелүүлээгүй эсвэл хөдөлмөрийн хамтын маргааныг хөдөлмөрийн арбитраар хэлэцсэн боловч түүний зөвлөмжийг хүлээн авч, шийдвэр гаргаагүй байвал мөн л тухайн ажилтанд ажил эрх нь бий. Гэхдээ ажилтан ажил хаялтад сайн дураараа оролцох ёстой. Хэн нэгний албан шаардлага, шахалтаар ажил хаялт зарлаж болохгүй. Мөн тухайн ажилтанд ажил хаялтад оролцох, түүнийг үргэлжлүүлэх, эсвэл хуульд зааснаас бусад тохиолдолд ажил хаялтыг зогсоох, түүнд оролцохоос татгалзахыг тулгаж шаардах

ёсгүй. Сайн дурын үндсэн дээр ажил хаялт зарлах ёстой.

-Ажил хаяг зохион байгуулсан, ажлын байрыг түр хаасныг хууль бус гэж үзэх үү?

-Хөдөлмөрийн хамтын маргааны улмаас зохион байгуулсан ажил хаялтыг мний дээр хэлсэн эрхүүдийг зөрчөөл хууль бус болж байгаа юм. Мөн батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журам сахиулах үүрэг бүхий байгууллагод ажил хаялт зохион байгуулж болохгүй. Хуульд заасан хамтын гэрээ, хэлэлцээрээр зохицуулах харилцаанд хамаарахгүй асуудлаар шаардлага тавьж ажил хаявал мөн л хууль бус болно. хэрвээ тухайн байгууллагын ажил олгогч, ажилтны аль нэг нь ажил хаялт зохион байгуулсан, ажлын байр түр хаасныг хууль бус гэж үзэж байгаа бол шүүхэд хүсэлт гаргах боломжтой. Үүний дараа шүүхээс хууль бус мөн эсэх талаар шийдвэр гаргана. Шүүхээс энэ ажил хаялт нь хууль бус гэсэн шийдвэр гарсан тохиолдолд ажил хаялтаа шууд зогсоох ёстой.

-Хууль бус ажил хаялт зарласан бол торгох уу?

-Хэрвээ ажил хаяхыг хориглосон байгууллагод ажил хаялт зохион байгуулбал иргэн, албан тушаалтныг 40-50 мянган төгрөгөөр торгодог. Харин аж ахуйн нэгж, байгууллагыг 100-200 мянган төгрөгөөр шүүгч торгоно.

Зурагтаас Хайлааст хүртэл шинэ зам тавина

Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгдчийн ээлжит хуралдаанаар Концессын гэрээ байгуулах тухай хэд хэдэн асуудлыг хэлэлцэн баталсан. Тухайлбал, Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороонд 83 дугаар цэцэрлэгийн 240 хүүхдийн өргөтгөл барих ажлыг нийслэлийн Концессын зүйлийн жагсаалтад оруулжээ. Тус ажлыг “Үүр тээл” ХХК гүйцэтгэхээр шалгарсан байна. Хайлааст шинээр барих цэцэрлэгийн өргөтгөл нь хоёр давхар, 1648 ам метр талбайтай байх бөгөөд концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр 240 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн зураг төсвийг боловсруулан, цэцэрлэгийн барилгыг барьж нийслэлийн өмчид шилжүүлэх аж. Мөн Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Тахилтын 188 дугаар цэцэрлэгийг өргөтгөж нэмж 150 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай болгох юм. Энэ төслийн санхүүжилт нь нэг сая 719 мянган төгрөг бөгөөд концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр цэцэрлэгийн барилга барьж, нийслэлийн өмчид шилжүүлэх юм байна. Мөн Хан-Уул дүүргийн 13

дугаар хорооны нутаг дэвсгэр, Туул тосгонд 150 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барихаар болжээ. Энэ төслийг “Цонбон тоосго” ХХК хэрэгжүүлэх аж. Эдгээр цэцэрлэгийн барилгыг энэ жилдээ дуусган ашиглалтад өгөхөөр төлөвлөж байгаа юм байна. Түүнчлэн нийслэлийн авто замын сүлжээг сайжруулах зорилгоор хэд хэдэн чиглэлд шинээр автозам барихаар төлөвлөж, стратегийн хувьд хамгийн чухалд тооцсон зарим замыг концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр баталсан. Тодруулбал, Хувьсгалчдын гудамжны авто замаас Хайлаастын авто зам хүртэлх 2.8 км авто замыг шинээр барих ажлыг “Рингроуд” ХХК-тай концессын гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр боллоо. Тус замыг Хувьсгалчдын гудамж буюу Зурагтаас Хайлааст хүртэл уулан дээгүүр тавих юм байна. Мөн Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо, Хуурай мухарын аманд шинээр 2.0 км авто зам барих төсөл, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Яргайтын Богиньн 1.6 км авто зам барих төслийг концессын гэрээгээр гүйцэтгэхээр болжээ.



PHOTO NEWS

Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хоороны дарга, МУ-ын Шадар сайд Ц.Оюунбаатар, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хоороны Нарийн бичгийн дарга Ё.Гэрэлчулуун нар наадмын бэлтгэл ажилтай танилцлаа. Одоогийн байдлаар Төв цэнгэлдэх хүрээлэнд нэлэлт гэрэлтүүлэг тавих, гол асарын үрд, хойд талын фасадыг засварлах, төв асарын суудлыг солих ажлыг хийх ют байна. Мөн Төв цэнгэлдэх хүрээлэнгийн үүдний хэсгийн баганыг сэргээн засварлах ажлыг хийх гэнэ.

Наадмаар ес хоног амарна

Ирэх сард тохиох монгол түмний үндэсний их баяр наадмаар ес хоног амрахаар болжээ. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр долдугаар сарын 11, 12, 13, 14, 15-нд байхаар хуульчилж, 2014 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар наадмаар үеэр ажлын таван өдөр амардаг болсон. Тэгвэл энэ жилийн тухайд долдугаар сарын 9, 10, 16, 17-нд амралтын өдрүүд таарч байгаа тул долдугаар сарын 8-наас эхлэн амарч, 18-нд ажил цуглах юм байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Хачигт хазуулах тохиолдол хоёр дахин нэмэгджээ

Хачигт халдвар өвчний сэжигтэй тохиолдлын тоо нэмэгдэж, өнгөрсөн он болон сүүлийн таван жилийн дунджаас хоёр дахин нэмэгджээ. Тодруулбал, хачигт халдварын сэжигтэй тохиолдол 16 аймгийн 80 гаруй сум, Улаанбаатар хотоос мэдээлэгдсэн байна. Тиймээс хөдөө, орон нутагт аялахдаа хачигт хазуулахаас сэрэмжлэхийг Эрүүл мэнд, спортын яамнаас анхаарууллаа.

Хөдөлмөрийн салбарт технологийн шинэчлэл хийв

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг КОЙКА байгууллага “Монгол Улсын хөдөлмөрийн салбарын мэдээллийн технологийн тогтолцоог хөгжүүлэх, цахим хурлын систем” төслийг Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төвд амжилттай хэрэгжүүлж, өннгөрсөн баасан гарагт хүлээлгэн өглөө. Энэхүү үйл ажиллагаанд Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, КОЙКА байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрынхан оролцсон. Тус төсөл нь 2015 оны есдүгээр сараас эхэлжээ. Төслийн үр дүнд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем бий болж хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажиллаж буй иргэд, мөн гадаадаас Монголд хөдөлмөр эрхлэж буй хүмүүсийг бүртгэхээс гадна тэдний тухай мэдээллийн цахим сан үүсгэх боломжтой

болсон аж. Төслийн хэрэгжилтийг танилцуулах үеэр Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан аймаг, дүүргүүд дэх 30 Хөдөлмөрийн хэлтсийн дарга нартай онлайнгаар зэрэг холбогдсон. Мөн тэрбээр, онлайнгаар холбогдсон Хөдөлмөрийн хэлтсийн дарга нарын уламжилсан зарим асуудлыг шийдвэрлэлээ. Ийнхүү КОЙКА байгууллагаас хэрэгжүүлсэн энэхүү төслийн хүрээнд хөдөлмөрийн салбарын удирдлага болон ажилчид онлайнгаар холбогдож, хурал хийх боломжтой болж байгаа ажээ. Мөн КОЙКА байгууллага төслийн хэрэгжилтийн талаар тайлан мэдээллийг албаны хүмүүст өгч, төслийн дараа хийгдэх ажлууд бий гэдгийг санууллаа. Тодруулбал, нэмэлт сургалт явуулах, гүйцэтгэлийн хэмжилт хийх, гарын авлага бэлдэх зэрэг ажлууд бөгөөд ирэх сарын дундуур дуусах юм байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 50 иргэн ажлын байртай болов

Чингэлтэй дүүрэгт хувиараа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтээгдэхүүн борлуулалтын төвийн байрны нээлт өнгөрсөн баасан гарагт боллоо. Тус төвийн нээлтэд Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, Чингэлтэй дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилчид болон иргэд оролцсон. Энэхүү төвийг Хөдөлмөрийн яамнаас энэ онд хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд шинээр байгуулжээ. Мөн тус төв ашиглалтад орсноор хувиараа болон хөгжлийн бэрхшээлтэй 50 орчим иргэд ажлын байртай болж байгаа аж. Нээлтийн үйл ажиллагааны үеэр Салбарын сайд Г.Баярсайхан “Бид Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих, Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийг энэ онд

хэрэгжүүлж байгаа. Энэ удаа Чингэлтэй дүүргийн хувиараа бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байр бэлдэж өглөө. Одоо та бүхэн бараа бүтээгдэхүүнээ борлуулах газар байхгүй гэж санаа зовох хэрэггүй болсон. Энэ төвд ямар нэгэн төлбөргүйгээр бараа бүтээгдэхүүнээ зарж болно. Өөрөөр хэлбэл, түрээсийн мөнгө авахгүй гэсэн үг” гэв. Дашрамд дурьдахад, Хөдөлмөрийн яам өнгөрсөн онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт Хөдөлмөр эрхлэлтийн сангаас хоёр сая 700 мянган тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Мөн 1988 байнгын ажлыг байранд 3540 иргэнийг хамруулжээ. Харин энэ жил гурван тэрбум төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажилд төсөвлөсөн байна.

ЗАВСАРЛАГА

УРЛАН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

СОНИРХУУЛАХАД

Майли Сайрус энэ зун гэрлэнэ

Б.ДАВААХҮҮ

Хөгжмийн салбарын хамгийн сахилгагүй, дүрсгүй оддын нэг Майли Сайрус хуримын зар дуулгалаа. Дуучин бүсгүйн хувьд “Өлсгөлөн тоглоом” киноны од жүжигчин Лиам Хемсворттой 2012 онд сүй тавьж байсан ч, 2013 онд тус тусын замаа хөөхөөр шийдсэн байдаг. Гэсэн ч салалтаасаа хойш хоёр жилийн дараа тэд эргэн нийлж, бүсгүйн хуруунд сүйн бөгж гялалзах болсон юм. Тэгвэл удтал хүлээлгэсний эцэст залуу хосууд дахин нийлж, хуримаа энэ зун Австралид

далайн эрэгт хийхээр төлөвлөсөн гэнэ. Тэд өнгөрөгч дөрөвдүгээр сарын сүүлээр хамтдаа Австралид аялсан бөгөөд энэ үеэр хуримаа хийх газраа сонгосон сурагтай. Үүнээс гадна сүйт бүсгүйн хамгийн тансаг, дэгжин чухал гоёлоо Майли Сайрус франц дизайнер Симоноор урлуулахаар болжээ. Лиам Хемсвортоос харилцаагаа тасалсан хоёр жилд Майли жүжигчин Арнолд Шварценеггерийн хүү Патриктэй үерхж байсан ч, тэдний харилцаа удаан үргэлжлээгүй юм.



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +21
Шөнө +8

Нөгөөдөр
Өдөр +23
Шөнө +7



Аргын тооллын:
2016 оны 6-р сарын 13,
Даваа гараг

Билгийн тооллын:
Шинийн 9. Таван шар
лэнгэтэй Улаан бар өдөр

Наран ургах/шингэх:
06:02 / 21:48

Үс засуулбал:
Өвчин очүүхэн ирээ



Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, талхи татах, сэтгэл луутантай нохойлох зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүл дуганыг сэргээх, альгуулах, оглогийн түлээ хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Гөлөг тэжээх, золиг гаргах, болбын үйл, хүхэд хөлд оруулахад туу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохойболтой. Хол газар яваар одогосод баруун урагш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МАНАЙ ДЭЛГЭЦНЭЭ...

Төгсөөрөөс илүү
ТЭНИС ГЭС...

tel: 313105

www.facebook.com/tengismovie
<https://ticket.tengis.mn>

<https://twitter.com/tengismovie>
www.tengis.mn

**1900-1617 -руу залгаад тасалбар захиалга,
үнэгүй хүргэлттэй боллоо**